



**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ
2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТОЙМ**


МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний 2025 оны 1 дүгээр улирлын арилжааны тойм

2025 оны 1 дүгээр улиралд нийт 245 удаагийн УУБ-ийн цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсан байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан “Эрдэнэс таван толгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Хангад эксплорэйшн” ХХК, “Андын Илч” ХХК нь 678.4 мянган тонн нүүрсийг 193.05 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь нийт 2.07 сая тонн төмрийн хүдэр болон баяжмалыг 431.07 тэрбум төгрөгөөр, “Очир Мандал Хайрхан” ХХК, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь нийт 11.6 мянган хайлуур жоншны хүдэр баяжмалыг 10.24 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ 5,000 тонн зэсийн баяжмалыг 33.05 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан бөгөөд нийт 2.77 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 667.4 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа

2025 оны 1 дүгээр улиралд нийт 94 удаагийн арилжаа амжилттай зохион байгуулагдаж нийт 2,767,735 тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалсанаас нүүрсний арилжаагаар 678,400 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 2,072,700 тонн төмрийн хүдэр болон баяжмал, жоншны арилжаагаар 11,635 тонн хайлуур жоншны хүдэр баяжмал, зэсийн арилжаагаар 5,000 тонн зэсийн баяжмал тус тус арилжигдсан байна. Нийт арилжааны 74.9 хувийг төмрийн хүдэр баяжмалын арилжаа, 24.5 хувийг нүүрсний арилжаа, 0.4 хувийг хайлуур жоншны хүдэр баяжмалын арилжаа, 0.2 хувийг зэсийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.

График1. 2025 оны 1 дүгээр улирлын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээнд эзлэх хувь.



1. Нүүрсний арилжаа

2025 оны 1 дүгээр улиралд нийт 24 удаагийн нүүрсний дуудлага арилжаа амжилттай зохион байгуулагдаж 678.4 мянган тонн нүүрсийг 193 тэрбум 53.32 сая төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 1.67 хувь байна. 2025 оны 1 дүгээр улиралд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан нүүрсний үнийн өсөлтөөс нийт 122.94 сая төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Тайлант хугацаанд 1 удаагийн нүүрсний арилжаагаар дунджаар 28.27 мянган тонн нүүрсийг 8.04 тэрбум төгрөгөөр арилжсан байна.


Хүснэгт1. 2025 оны 1 дүгээр улиралд арилжигдсан нүүрсний хэмжээ, үнийн дүн.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /төгрөг/
1	Баяжуулсан коксжих нүүрс	256,000	102,292,829,101
2	1/3 коксжих нүүрс	192,000	47,983,105,792

3	Баяжуулсан коксжих чанаргүй нүүрс	140,800	24,595,283,763
4	Баяжуулсан сул коксжих нүүрс	51,200	14,868,076,800
5	Чийг багатай хүрэн нүүрс	38,400	3,314,027,520
Нийт		678,400	193,053,322,976


Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 52.99 хувь буюу 102.29 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 24.85 хувь буюу 47.98 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 12.74 хувь буюу 24.6 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих чанаргүй нүүрсний арилжаа, 7.7 хувь буюу 14.87 тэрбум төгрөгийг Баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 1.72 хувь буюу 3.31 тэрбум төгрөгийг Чийг багатай хүрэн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

График2. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /бүтээгдэхүүний төрлөөр/.



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 76.41 хувь буюу 147.52 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс таван толгой” ХК, 11.75 хувь буюу 22.67 тэрбум төгрөгийн арилжааг “Хангад Эксплорэйшн” ХХК, 10.13 хувь буюу 19.55 тэрбум төгрөгийн арилжааг “Энержи ресурс” ХХК, 1.72 хувь буюу 3.31 тэрбум төгрөгийн арилжааг “Андын Илч” ХХК тус тус эзэлж байна.

График3. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниуд/.



2025 оны 1 дүгээр улиралд нийт 24 нүүрсний арилжаа амжилттай явагдсан. Үүнд:


- 1 дүгээр сард нийт 10 удаагийн нүүрсний арилжаагаар 256,000 тонн буюу 63.78 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард нийт 4 удаагийн нүүрсний арилжаагаар 172,800 тонн буюу 59.17 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард нийт 10 удаагийн нүүрсний арилжаагаар 249,600 тонн буюу 70.1 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан.

2. Төмрийн хүдэр, баяжмалын арилжаа

2025 оны 1 дүгээр улиралд нийт 65 удаагийн

График4. 2025 оны 1 дүгээр улиралд арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал

арилжаагаар 2,072.7 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 431.07 тэрбум төгрөгөөр арилжсан. Үүнд: 1,765,800 тонн буюу 362.86 тэрбум төгрөгийн төмрийн баяжмал, 306,900 тонн буюу 68.21 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр тус тус арилжигдсан байна. Тодруулбал: Fe – 65%-ийн төмрийн баяжмал 118,800 тонн буюу 35.84 тэрбум төгрөг, Fe – 58%-ийн төмрийн баяжмал 1,647,000 тонн буюу 327.01 тэрбум төгрөг, Fe-52%-ийн төмрийн хүдэр 306,900 тонн буюу 68.21 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийсэн байна. Үүнд



- 1 дүгээр сард 30 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 1,010,100 тонн буюу 207.9 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард 21 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 917,400 тонн буюу 185.33 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард 14 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 145,200 тонн буюу 37.83 тэрбум төгрөгийн арилжаа,

Дуудлага худалдаагаар арилжсан төмрийн хүдэр болон баяжмалын үнийн өсөлтийн дундаж 3.54 хувь байна. Төмрийн баяжмал, хүдрийн арилжааны нийт үнийн дүнгийн 75.86 хувь буюу 327.01 тэрбум төгрөгийн арилжааг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК, 24.14 хувь буюу 104.05 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Критикал Минералс”ТӨҮГ тус тус эзэлж байна. 2025 оны 1 дүгээр улиралд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан төмрийн баяжмал, хүдрийн үнийн өсөлтөөс нийт 2.98 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

3. Зэсийн баяжмалын арилжаа

2025 оны 1-р улиралд “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь нийт 5.0 мянган тонн 22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмалыг 33.05 тэрбум төгрөгөөр арилжсан арилжаалсан байна.

4. Хайлуур жоншны баяжмалын арилжаа

2025 оны 1-р улиралд нийт 4 удаагийн арилжаагаар 11.6 мянган тонн хайлуур жоншны хүдэр баяжмалыг 10.24 тэрбум төгрөгөөр арилжсан. Үүнд:

- 2 дугаар сард 1 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 3,315 тонн буюу 4.1 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард 3 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 8,320 тонн буюу 6.1 тэрбум төгрөгийн арилжаа тус тус амжилттай зохион байгуулагдсан байна.

Тайлант хугацаанд “Эрдэнэс Критикал Минералс”ТӨҮГ нь 6.6 мянган тонн CaF_2 -97%-ийн хайлуур жоншны баяжмалыг 8.5 тэрбум төгрөгөөр, “Очир мандал хайрхан” ХХК нь 5.0 мянган тонн $\text{CaF}_2 < 55\%$ -ийн хайлуур жоншны хүдрийг 1.7 тэрбум төгрөгөөр, арилжаалсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА, БҮРТГЭЛИЙН ГАЗАР